



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/157

Улаанбаатар хот

Зам талбайн чийгшүүлэлт, усалгаа хийх
хуваарь батлах тухай


Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, 23 дугаар зүйлийн 23.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын гудамж талбайн цэвэрлэгээ, арчилгаа, хамгаалалтын ажилд байгууллага, аж ахуйн нэгж иргэнийг гэрээгээр оролцуулах журам"-ын 4 дүгээр хэсгийн 4.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Төсөв батлах тухай" 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/285 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 тоот албан даалгавар, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.5, 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.4, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хотын тоосжилтыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын зарим гол гудамж, зам талбай, ногоон байгууламжийн усалгаа, чийгшүүлэлт хийх хуваарийг 1 дүгээр, шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу ус шүрших зориулалтын хошуу бүхий усны автомашинтай нийслэл, дүүргийн тохижилт, үйлчилгээний компанид дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.


3. Хариуцсан дүүргийн зам талбайн усалгаа, чийгшүүлэлтийн ажилд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг төлөөлөн өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг хог хаягдлын үйлчилгээний хяналтын Төрийн бус байгууллагуудад тус тус үүрэг болгосугай.

4. Зам талбайн усалгааны ажилд шаардагдах 20,824,164 /хорин сая, найман зуун хорин дөрвөн мянга, нэг зуун жаран дөрөв/ төгрөгийг ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  СГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 10 сарын 31-ны
 өдрийн А/157 дугаар тушаалын 1-р хавсралт



УСАЛГАА, ЧИЙГШҮҮЛЭЛТ ХИЙХ ЗАМ ТАЛБАЙН ХУВААРЬ

Хот тохижилтын газар

№	Гудамжны нэр	Байршил	Урт /км/
1	Энхтайваны өргөн чөлөө	Скадрилын хөшөөнөөс Саппоро хүртэл	9.2
2	Москвагийн гудамж	Саппорогоос Геологийн төв лабораторийн уулзвар хүртэл	2.7
3	Сөүлийн гудамж	УДЭТ-аас Баруун 4 зам хүртэл	2.4
4	Чингисийн өргөн чөлөө	Төв шуудангаас Тэмээтэй уулзвар хүртэл	2
5	Зайсангийн гудамж	Тэмээтэй уулзвараас ХААИС-ын хойд уулзвар хүртэл	2
6	Их Монгол улсын гудамж	Home plaza-аас Их тэнгэрийн уулзвар хүртэл	2.3
НИЙТ			20.6

№	Гудамжны нэр	Байршил	Урт /км/
1	Тасганы овооны зам	Баянбүрдийн тойргоос баруун тийш Тасганы овооны уулзвар хүртэл	0.9
2	Ард Аюушийн өргөн чөлөө	Тролейбусны эцсийн буудлаас Саппорогийн уулзвар хүртэл	1.7
3	С.Амарсанаагийн гудамж	Энхтайваны өргөн чөлөө, Барилгын техникумын баруун талын замын уулзвараас дээш Л.Энэбишийн өргөн чөлөө хүртэл	1.0
4	Х.Чингүнжавын гудамж	Энхтайваны өргөн чөлөө, Төмөр замын нэгдсэн эмнэлэгийн хойт талын уулзвараас хойш Ард Аюушийн өргөн чөлөө болон Л.Энэбишийн өргөн чөлөөний огтлолцол хүртэл	0.9
5	Жалханз Хутагт Дамдинбазарын гудамж	Амарсанаагийн гудамжнаас баруун тийш хороолол дундуур Чингүнжавийн гудамж хүртэл	1.1
6	Дилав хутагт Жамсранжавын гудамж	Чингүнжавын гудамжнаас баруун тийш Гэмтлийн эмнэлэгийн урд талаар Ард Аюушийн өргөн чөлөө хүртэл	1.7
7	Ард Аюушийн өргөн чөлөө	Өргөө кино театрын уулзвараас баруун тийш Тролейбусны эцсийн буудал хүртэл	0.7
8	Энэбишийн өргөн чөлөө	Тасганы овооны уулзвараас баруун тийш Өргөө кино театрын уулзвар хүртэл	1.5
9	Занабазарын гудамж	Баруун 4 замаас Гандан хүртэл	0.6
НИЙТ			10.1

Чингэлтэй тохижилт үйлчилгээ ХХК

№	Гудамжны нэр	Байршил	Урт /км/
1	Самбуугийн гудамж	Гэсэр сүмийн уулзвараас Байгалийн түүхийн музейн урд уулзвар хүртэл	1.1
2	Амарын гудамж	СТӨ-ний баруун хойд уулзвараар зүүн тийш СТО хүртэл	0.3
3	Жуулчны гудамж	Хэлмэгдэстийн хөшөөнөөс баруун тийш Урт цагаан хүртэл	0.7
4	Залуучуудын гудамж	БНХАУ-ын Элчин сайдын ямны урд уулзвараас баруун тийш байгалийн түүхийн музейн уулзвар хүртэл	0.6
5	Бээжингийн гудамж	Е Mart их дэлгүүрийн зүүн хойд уулзвараас БНХАУ-ын Элчин сайдын ямны урд уулзвар хүртэл	0.9
6	Бага тойруу	Цэцэг төвийн уулзвараас хойш тойроод Багшийн их сургуулийн уулзвар хүртэл /Анкара ороогүй/	2.0
7	Их сургуулийн гудамж	Гадаад хэргийн яамны уулзвараас хойш Их тойруу хүртэл	1.3
8	Сүхбаатарын гудамж	Төв шуудангийн уулзвараас хойш Их тойруу хүртэл	1.3
НИЙТ			8.2

“Хан-Уул тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ

№	Гудамжны нэр	Байршил	Урт /км/
1	Чингисийн өргөн чөлөө	Тэмээтэй уулзвараас баруун тийш ТЭЦ-3-ын зүүн урд уулзвар хүртэл	2.5
НИЙТ			2,5

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 12 дугаар сарын 31-ны
өдрийн 1 дугаар тушаалын 2-р хавсралт



УСАЛГАА, ЧИЙГШҮҮЛЭЛТ ХИЙХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хариуцах байгууллгын нэр	Зам талбайн урт /км/	1 км зам услах нэгж зардал /₮/	1 өдрийн зардал	4 сарын хугацаанд 60 удаа услах нийт зардал
“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ	20.6	8335	171,701	10,302,060
“Баянгол шинэ өргөө” ОНААТҮГ	10.1	8335	84,184	5,051,010
“Хан-Уул тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ	2.5	8335	20,838	1,250,250
“Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ” ХХК	8.4	8335	70,347	4,220,844
НИЙТ	41.6			20,824,164